ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

## ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

**АУДИТЫН КОД: ТӨА-2024/103/-НА-СТА-ТШЗ**

**ТӨВ АЙМГИЙН ЖАРГАЛАНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2023 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН**

Зуунмод 2024 он


Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор Ц.Саранчимэг

Утас: 70273204 Цахим хаяг: saranchimeg.ts@audit.gov.mn


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

АГУУЛГА

**1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ** ........ 3
**3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА** ........ 10
**4. АУДИТЫН ТАЙЛАН** ........ 15
**4.1 Ерөнхий зүйл** ........ 15
**4.2 Материаллаг байдал** ........ 15
**4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт** ........ 15
**4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал** . 15
**4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт** ........ 15
**4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт** ........ 16
**4.5.1 Завсрын аудитын талаар** ........ 16
**4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал** ........ 16
**5.1 Төлбөрийн акт** ........ 17
**5.2 Албан шаардлага** ........ 18
**5.3 Зөвлөмж** ........ 18
**6. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА,ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ** ........ 22
**6.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл** ........ 22
**6.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл** ........ 22
**6.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал** . 23

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |
| ИТХ | Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал |
| ЗДТГ | Засаг даргын Тамгын газар |
| ХК | Хувьцаат компани |
| ТӨХК | Төрийн өмчит Хувьцаат компани |
| ОНӨҮГ | Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар |

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2024.02.28 № 01/64
танай ______-ны № ______-т

ТӨВ АЙМГИЙН ЖАРГАЛАНТ СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА В.БОЛОРТУЯА ТАНАА

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Жаргалант сумын Засаг даргын тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Төв аймгийн Жаргалант сумын Засаг даргын тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Төв аймгийн Жаргалант сумын Засаг даргын тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар хөрөнгийн болон бараа материалын тооллогын бүртгэлийн дүн тайлангаас зөрүүтэй, бараа материалыг орлогын авахдаа бөөн дүнгээр орлогодсон, хөрөнгийн ашиглах хугацааг буруу бүртгэсэн, элэгдлээр анхны өртгөө нөхсөн үлдэх өртөггүй хөрөнгийг дахин үнэлэх болон хугацааг сунгах талаар ажиллаагүй, төрийн мэдлийн газар эзэмших эрхийн бүртгэл зөрүүтэй, бараа үйлчилгээний бусад зардал болон бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг, ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас хөрөнгө бэлтгэсэн, хуульд заагаагүй нэмэгдлийг улс төрийн албан хаагчдад эхний 6 сар олгосон, төлбөрийн шилжүүлсэн дүн цахим баримтын дүнгээс зөрүүтэй зэрэг нийт 1,067,205.9 мянган төгрөгийн зөрчил илэрч, тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан нь дангаараа буюу эсвэл нийтээрээ санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй, санхүүгийн тайлангийн аудитын “нийцсэн бөгөөд зохистой байх”, “эрх ба үүрэг”, “иж бүрэн байх” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

### Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант оны үйл явцыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно. Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. ЗДТГ нь 2023 онд төсвийн хөрөнгөөр 216,719.6 мянган төгрөгийн,

Орон нутгийн хөгжлийн сан, бусад эх үүсвэрээр бэлтгэсэн 1,150,148.7 мянган төгрөгийн хөрөнгийг сайжруулалт болон үндсэн хөрөнгөнд орлого авч бүртгэсэн байна.

**Аудитын гол асуудал**

Санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх материаллаг буруу илэрхийлэл, нөлөө бүхий эрсдэл байхгүй байна. Шинэ хөдөө төсөл хэрэгжиж хадуур, өвс хаман боогч, үрлүүр, трактор зэрэг бүрэн тоног төхөөрөмж, техник хэрэгслийг түрээсийн гэрээгээр ашиглаж үр дүнг тооцож ажилласан байна.

**Бусад асуудлын хэсэг**

Санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал гараагүй болно. Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.ХИШИГЖАРГАЛ

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон /төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **85,898,082.46** | **109,723,613.46** |
| **33** | **АВЛАГА** | **1,510,200.00** | **0** |
| **33500** | **Бусад авлага** | **1,510,200.00** | **0** |
| 33510 | Байгууллагаас авах авлага | 1,510,200.00 | 0 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **84,387,882.46** | **109,723,613.46** |
| **35100** | **Түүхий эд материал** | **6,523,558.00** | **6,393,889.00** |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 6,523,558.00 | 6,393,889.00 |
| **35400** | **Хангамжийн материал** | **77,864,324.46** | **103,329,724.46** |
| 35410 | Бичиг хэргийн материал | 461,200.00 | 1,148,400.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 2,015,200.00 | 1,937,300.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 24,236,500.00 | 38,336,500.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 3,392,000.02 | 7,772,800.02 |
| 35450 | Барилгын засварын материал | 857,400.00 | 5,405,100.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 46,902,024.44 | 48,729,624.44 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **2,513,785,145.17** | **3,497,909,939.53** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **2,513,785,145.17** | **3,497,909,939.53** |
| **39200** | **Биет хөрөнгө** | **2,325,194,185.13** | **3,304,409,139.53** |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1,478,581,423.32 | 2,342,965,447.32 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -436,625,032.02 | -531,849,175.13 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 523,441,346.61 | 602,801,346.61 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -277,041,172.55 | -343,568,559.18 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж(компьютер) | 297,173,815.64 | 334,435,736.22 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -143,589,096.71 | -173,745,385.62 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 93,384,257.00 | 138,164,634.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -37,045,440.37 | -44,816,233.33 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 1,090,839,437.00 | 1,415,566,042.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -263,925,352.79 | -435,544,713.36 |
| **39300** | **Биет бус хөрөнгө** | **188,590,960.04** | **193,500,800.00** |
| 39301 | Програм хангамж | 450,000.00 | 3,450,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -450,000.00 | -450,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 190,500,800.00 | 190,500,800.00 |
| 39304 | Хуримтлагдсан элэгдэл | -1,909,839.96 | 0 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **2,599,683,227.63** | **3,607,633,552.99** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **2,599,683,227.63** | **3,607,633,552.99** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | **2,599,683,227.63** | **3,607,633,552.99** |
| 511002 | Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө | 460,393,479.67 | 460,393,479.67 |
| **51200** | **Хуримтлагдсан үр дүн** | **1,428,345,663.68** | **2,436,389,020.24** |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 775,218,019.15 | 1,430,348,534.84 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 653,127,644.53 | 1,006,040,485.40 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 710,944,084.28 | 710,851,053.08 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **2,599,683,227.63** | **3,607,633,552.99** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон /төгрөгөөр

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,426,837,044.82** | **733,761,682.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **781,892,869.00** | **686,240,342.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **781,892,869.00** | **686,240,342.00** |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 767,209,869.00 | 651,399,042.00 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | 14,683,000.00 | 34,841,300.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **644,944,175.82** | **47,521,340.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **147,202,438.82** | **47,521,340.00** |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан | 124,615,873.00 | 42,410,340.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны | 22,586,565.82 | 5,111,000.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **497,741,737.00** | **0** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн | 497,741,737.00 | 0 |
| **II** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **773,506,900.29** | **1,051,724,690.33** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **773,506,900.29** | **1,051,724,690.33** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **700,892,596.11** | **1,029,843,391.69** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **210,827,231.29** | **454,347,911.36** |
| 210101 | Үндсэн цалин | 182,519,514.54 | 260,936,804.69 |
| 210102 | Нэмэгдэл | 28,307,716.75 | 119,011,620.58 |
| 210104 | Урамшуулал | 0 | 21,572,051.21 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 0 | 52,827,434.88 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх** | **26,643,318.28** | **58,457,028.97** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 18,369,900.54 | 39,726,166.24 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,068,379.43 | 4,684,789.87 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,654,683.55 | 3,877,947.13 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 413,695.89 | 936,997.97 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,136,658.87 | 9,231,127.76 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **45,330,931.97** | **64,892,515.58** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 11,766,902.96 | 17,922,213.65 |
| 210302 | Түлш, халаалт | 33,564,029.01 | 46,970,301.93 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **34,710,089.97** | **36,777,391.26** |
| 210401 | Бичиг хэрэг | 2,070,000.00 | 2,810,400.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 20,879,239.97 | 16,091,847.52 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,300,000.00 | 1,175,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, | 6,843,350.00 | 15,261,374.74 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 3,617,500.00 | 1,438,769.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **0** | **969,900.00** |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 0 | 969,900.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **2,863,424.00** | **1,339,886.92** |
| 210604 | Урсгал засвар | 2,863,424.00 | 1,339,886.92 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **2,333,000.00** | **2,512,000.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 2,333,000.00 | 2,512,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний** | **81,467,906.11** | **5,701,530.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил | 80,410,694.11 | 3,977,990.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 604,800.00 | 720,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 200,000.00 | 400,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 186,412.00 | 493,540.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 66,000.00 | 110,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **296,716,694.49** | **404,845,227.60** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 120,025,833.00 | 42,847,690.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 176,690,861.49 | 361,997,537.60 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **72,614,304.18** | **21,881,298.64** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **68,682,967.00** | **17,749,000.00** |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 16,260,000.00 | 0 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 51,812,967.00 | 16,749,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 610,000.00 | 1,000,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад** | **3,931,337.18** | **4,132,298.64** |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 3,931,337.18 | 4,132,298.64 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)** | **653,330,144.53** | **-317,963,008.33** |
| **V** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | **202,500.00** | **0** |
| 225001 | Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз | 202,500.00 | 0 |
| **VI** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)** | **653,127,644.53** | **-317,963,008.33** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон /төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)** | **644,944,175.82** | **945,933,540.00** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **644,944,175.82** | **945,933,540.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **147,202,438.82** | **47,521,340.00** |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс | 124,615,873.00 | 42,410,340.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий | 22,586,565.82 | 5,111,000.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **497,741,737.00** | **898,412,200.00** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт | 497,741,737.00 | 898,412,200.00 |
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **596,328,075.82** | **729,213,916.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **596,328,075.82** | **729,213,916.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **523,513,771.64** | **656,830,085.09** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **210,827,231.29** | **454,347,911.36** |
| 210101 | Үндсэн цалин | 182,519,514.54 | 260,936,804.69 |
| 210102 | Нэмэгдэл | 28,307,716.75 | 119,011,620.58 |
| 210104 | Урамшуулал | 0 | 21,572,051.21 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 0 | 52,827,434.88 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **26,643,318.28** | **58,457,028.97** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 18,369,900.54 | 39,726,166.24 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,068,379.43 | 4,684,789.87 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,654,683.55 | 4,028,265.11 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 413,695.89 | 936,997.97 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,136,658.87 | 9,080,809.78 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **48,576,758.96** | **69,273,315.58** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 11,766,902.96 | 17,922,213.65 |
| 210302 | Түлш, халаалт | 36,809,856.00 | 51,351,101.93 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **30,745,300.00** | **37,689,372.26** |
| 210401 | Бичиг хэрэг | 1,982,000.00 | 3,499,600.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 20,213,200.00 | 15,383,397.52 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,300,000.00 | 1,175,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 7,250,100.00 | 17,631,374.74 |
| **2105** | **Нормативт зардал** | **0** | **996,900.00** |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 0 | 996,900.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **2,613,424.00** | **2,297,386.92** |
| 210604 | Урсгал засвар | 2,613,424.00 | 2,297,386.92 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **2,333,000.00** | **2,512,000.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 2,333,000.00 | 2,512,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр,** | **81,467,906.11** | **5,717,130.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний | 80,410,694.11 | 3,993,590.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 604,800.00 | 720,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 200,000.00 | 400,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 186,412.00 | 493,540.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 66,000.00 | 110,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **120,306,833.00** | **25,539,040.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 120,306,833.00 | 25,539,040.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **72,814,304.18** | **72,383,830.91** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **68,882,967.00** | **17,749,000.00** |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 16,260,000.00 | 0 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 51,812,967.00 | 16,749,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 810,000.00 | 1,000,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох** | **3,931,337.18** | **54,634,830.91** |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 3,931,337.18 | 54,634,830.91 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)** | **48,616,100.00** | **216,719,624.00** |
| **V** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)** | **48,616,100.00** | **216,719,624.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **48,616,100.00** | **216,719,624.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | **48,616,100.00** | **216,719,624.00** |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 48,616,100.00 | 216,719,624.00 |
| **VI** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **-48,616,100.00** | **-216,719,624.00** |
| **VIII** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)** | **0** | **0.00** |
| 101 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 0 | 0 |
| 20 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 0 | 0 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон /төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| 1 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **460,393,479.7** | **711,098,900.5** | **775,063,203.0** | **1,946,555,583.1** |
| 2 | **Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт** | **0.0** | **0.0** | **154,816.2** | **154,816.2** |
| 3 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **460,393,479.7** | **711,098,900.5** | **775,218,019.2** | **1,946,710,399.3** |
| 4 | **Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт** | **0.0** | **-154,816.2** | **0.0** | **-154,816.2** |
| 9 | **Тайлант үеийн үр дүн** | **0.0** | **0.0** | **653,127,644.5** | **653,127,644.5** |
| 10 | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **460,393,479.7** | **710,944,084.3** | **1,428,345,663.7** | **2,599,683,227.6** |
| 11 | **2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **460,393,479.7** | **710,944,084.3** | **1,428,345,663.7** | **2,599,683,227.6** |
| 12 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0.0 | 0.0 | 2,002,871.2 | 2,002,871.2 |
| 13 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **460,393,479.7** | **710,944,084.3** | **1,430,348,534.8** | **2,601,686,098.8** |
| 14 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | 0.0 | -93,031.2 | 0.0 | -93,031.2 |
| 19 | Тайлант үеийн үр дүн | 0.0 | 0.0 | 1,006,040,485.4 | 1,006,040,485.4 |
| 20 | **2023 оны 6-р сарын 30-наарх үлдэгдэл** | **460,393,479.7** | **710,851,053.1** | **2,436,389,020.2** | **3,607,633,553.0** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон /төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Өмнөх оны | | Тайлант оны | |
|---|---|---|---|---|---|
| | | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР** | **561,207,800.00** | **493,876,915.64** | **898,412,200.00** | **849,896,970.21** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **561,207,800.00** | **493,876,915.64** | **701,118,600.00** | **652,603,346.21** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ** | **507,827,600.00** | **441,253,948.64** | **683,369,600.00** | **634,854,346.21** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл** | **216,493,600.00** | **210,827,231.29** | **437,335,200.00** | **423,198,896.84** |
| 210101 | Үндсэн цалин | 177,308,900.00 | 182,519,514.54 | 255,384,300.00 | 254,787,930.44 |
| 210102 | Нэмэгдэл | 39,184,700.00 | 28,307,716.75 | 127,500,900.00 | 94,011,480.31 |
| 210104 | Урамшуулал | 0 | 0 | 0 | 21,572,051.21 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 0 | 0 | 54,450,000.00 | 52,827,434.88 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн** | **27,468,500.00** | **26,643,318.28** | **54,571,900.00** | **54,563,402.13** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 19,054,200.00 | 18,369,900.54 | 37,078,500.00 | 37,078,500.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,103,600.00 | 2,068,379.43 | 4,373,300.00 | 4,373,299.70 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,682,900.00 | 1,654,683.55 | 3,498,700.00 | 3,498,699.70 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 420,700.00 | 413,695.89 | 874,700.00 | 874,699.94 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,207,100.00 | 4,136,658.87 | 8,746,700.00 | 8,738,202.79 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой** | **68,291,700.00** | **48,576,758.96** | **85,056,600.00** | **69,273,315.58** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 16,758,500.00 | 11,766,902.96 | 20,822,400.00 | 17,922,213.65 |
| 210302 | Түлш, халаалт | 51,374,600.00 | 36,809,856.00 | 64,034,200.00 | 51,351,101.93 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 158,600.00 | 0 | 200,000.00 | 0 |
| **2104** | **Хангамж, бараа материалын** | **37,071,000.00** | **20,974,550.00** | **40,262,100.00** | **36,869,374.74** |
| 210401 | Бичиг хэрэг | 1,527,000.00 | 1,527,000.00 | 3,500,000.00 | 3,499,600.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 10,936,000.00 | 10,897,450.00 | 14,762,100.00 | 14,563,400.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,608,000.00 | 1,300,000.00 | 2,000,000.00 | 1,175,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон | 23,000,000.00 | 7,250,100.00 | 20,000,000.00 | 17,631,374.74 |
| **2105** | **Нормативт зардал** | **0** | **0** | **1,000,000.00** | **996,900.00** |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 0 | 0 | 1,000,000.00 | 996,900.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын** | **3,201,100.00** | **2,803,324.00** | **2,300,000.00** | **2,297,386.92** |
| 210604 | Урсгал засвар | 3,201,100.00 | 2,803,324.00 | 2,300,000.00 | 2,297,386.92 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **2,333,000.00** | **2,333,000.00** | **4,373,000.00** | **2,512,000.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 2,333,000.00 | 2,333,000.00 | 4,373,000.00 | 2,512,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил,** | **77,279,000.00** | **71,819,189.11** | **11,520,000.00** | **9,959,130.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад | 75,259,000.00 | 70,761,977.11 | 9,500,000.00 | 8,235,590.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл | 720,000.00 | 604,800.00 | 720,000.00 | 720,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 400,000.00 | 200,000.00 | 400,000.00 | 400,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 750,000.00 | 186,412.00 | 750,000.00 | 493,540.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 150,000.00 | 66,000.00 | 150,000.00 | 110,000.00 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон /төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | ТЗ цэвэр дүн | ТЗ цэвэр дүн |
|---|---|---|---|
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **147,202,438.82** | **47,521,340.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **147,202,438.82** | **47,521,340.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **130,875,923.00** | **41,401,738.88** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **0** | **31,149,014.52** |
| 210101 | Үндсэн цалин | 0 | 6,148,874.25 |
| 210102 | Нэмэгдэл | 0 | 25,000,140.27 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **0** | **3,893,626.84** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 0 | 2,647,666.24 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 0 | 311,490.17 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 0 | 529,565.41 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 0 | 62,298.03 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 0 | 342,606.99 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **9,770,750.00** | **819,997.52** |
| 210401 | Бичиг хэрэг | 455,000.00 | 0 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 9,315,750.00 | 819,997.52 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **9,648,717.00** | **1,194,000.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр | 9,648,717.00 | 1,194,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **111,456,456.00** | **4,345,100.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 111,456,456.00 | 4,345,100.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **16,326,515.82** | **6,119,601.12** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **16,260,000.00** | **0** |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 16,260,000.00 | 0 |
| **2133** | **Олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **66,515.82** | **6,119,601.12** |
| 213305 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт,нэмэлт санхүүжил | 66,515.82 | 0 |
| 213403 | Орон нутгийн төсвийн төвлөрүүлэх шилжүүлэг | 0 | 6,119,601.12 |
| **I** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **147,202,438.82** | **47,521,340.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **147,202,438.82** | **47,521,340.00** |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 124,615,873.00 | 42,410,340.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 22,586,565.82 | 5,111,000.00 |
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 0 | 0 |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 0 | 0 |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төв аймгийн Жаргалант сумын Засаг даргын Тамгын газар нь Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1-д “Аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг даргын ажлын алба нь тамгын газар байх бөгөөд доор дурдсан чиг үүргийг хэрэгжүүлнэ” гэж заасны дагуу 67.1.1-67.1.8-д заасан чиг үүргийг хэрэгжүүлдэг, Төв аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллага юм.

Төв аймгийн Жаргалант сумын Засаг даргын Тамгын газрын тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Төв аймгийн Жаргалант сумын Засаг даргын Тамгын газар нь сумын Засаг даргатай 2023 оны байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг 5 зорилтын хүрээнд 27 арга хэмжээ батласнаас 24 арга хэмжээ бүрэн хэрэгжиж 92.0%-тай дүгнэгдсэн байна.

Төв аймгийн Жаргалант сумын Засаг даргын Тамгын газрын даргын 2023 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн А/01 тоот тушаалаар байгууллагын бүтэц, орон тоог төрийн захиргааны 9, төрийн үйлчилгээний 7 албан хаагчтайгаар баталж, үйл ажиллагаагаа явуулсан байна.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Төв аймгийн Жаргалант сумын Засаг даргын Тамгын газар нь сумын ИТХ, Засаг даргын бодлого боловсруулж, шийдвэр гаргахад нь бүх талын дэмжлэг туслалцаа үзүүлэх замаар төрийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай хүргэн төрийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, иргэдийн ажиллах амьдрах таатай орчин бүрдүүлэх, төрийн албаны шинэчлэлд суурилсан "Ёс зүйтэй, хариуцлагатай, хяналттай" төрийн албыг төлөвшүүлэн, "Иргэн төв"-тэй төрийн цахим үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, төрийн үйлчилгээний гүйцэтгэлийн үр нөлөө болон чанарыг нэмэгдүүлэх, байгууллагын үр ашиг болон бүтээмжийг дээшлүүлэх, хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэн, албан хаагчид нь шинийг эрэлхийлж, үйл ажиллагааны ил тод байдлыг хангах зорилгоор цахим мэдээллийг хөгжүүлэн, ТАХ-ын ажлын сахилга хариуцлага, гүйцэтгэлийн удирдлагыг сайжруулан, багаараа өндөр бүтээмжтэй ажиллах зорилтын хүрээнд үйл ажиллагаагаа чиглүүлэн ажилласан байна.

Төв аймгийн Жаргалант сумын Засаг даргын Тамгын газар нь төсвийн шууд захирагчийн хувьд дараах хуулийн хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хууль
- Төрийн хэмнэлтийн тухай хууль
- Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын хууль

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд буюу хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн өөрчлөлттэй холбоотой өөрчлөлтийг нэмж тусган мөрдөж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэхэд, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Төлөвлөлтийн үе шатанд дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзсэн.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Жаргалант сумын Засаг даргын Тамгын газар нь 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь 2013 онд аймгийн хэмжээнд батлагдсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг санхүүгийн үйл ажиллагаандаа мөрдөж байгаа ба тус бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцээгүй бөгөөд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэн боловсруулах шаардлагатай байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Жаргалант сумын Засаг даргын тамгын газар нь 2023 оны санхүүгийн тайлангаа Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэж, 2024 оны 1 дүгээр сарын 24-ний өдрийн №03/45 албан тоотоор Төрийн аудитын газарт ирүүлсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,007,950.3 мянган төгрөгөөр буюу 38,8 хувиар өссөн байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

| **Үзүүлэлт** | **Эхний үлдэгдэл** | **Эцсийн үлдэгдэл** | **Өөрчлөлт** |
|---|---|---|---|
| А | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | - | - | - |
| Авлага | 1,510.2 | - | -1,510.2 |
| Урьдчилгаа | - | - | - |
| Бараа материал | 84,387.9 | 109,723.6 | 25,335.7 |
| Үндсэн хөрөнгө | 2,513,785.1 | 3,497,909.9 | 984,124.8 |
| **Нийт хөрөнгө** | **2,599,683.2** | **3,607,633.6** | **1,007,950.3** |
| Өр төлбөр | - | - | - |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 2,599,683.2 | 3,607,633.6 | 1,007,950.3 |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **2,599,683.2** | **3,607,633.6** | **1,007,950.3** |

Дээрх хүснэгтээс харахад, өмнөх онд үүссэн авлагын үлдэгдэл 1,510.2 мянган төгрөгийг барагдуулсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 109,723.6 мянган төгрөг болж, оны эхний үлдэгдлээс 25,335.7 мянган төгрөгөөр өссөн байна.

Энэ нь нийгмийн хариуцлагын гэрээний хүрээнд Тэнхун ХХК-аас 23,130.0 мянган төгрөгийн ковш тракторын дугуй, сэлбэг хэрэгсэл, цагдаагийн машины сэлбэг, land200 автомашины дугуй, Дэлхийн зөн ОУБ-ын Төв салбараас 4,163.7 мянган төгрөгийн барилгын материалыг үнэ төлбөргүй хүлээн авсан нь нөлөөлсөн байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 984,124.8 мянган төгрөгөөр өссөн байна.

Аймгийн Засаг даргын 2023 оны 5 дугаар сарын 25-ны А/355 дугаар захирамжийн дагуу УИХ-ын гишүүний хүлээлгэн өгсөн 5 зөөврийн компьютер, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр бэлтгэсэн болон бусад эх үүсвэрээр бэлтгэсэн 641,789.4 мянган төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүй хүлээн авсан байна.

ЗДТГ-ын конторын барилгыг болон төвийн худаг, малчны хорооны худаг, явган зам, Загдал конторын барилгыг сайжруулалтаар бүртгэсэн байна.

Төсвийн хөрөнгөөр модны суулгац 11,990.0 мянган төгрөг, санхүүд 14,499.5 мянган төгрөгийн компьютер тоног төхөөрөмж, Моностойн булгийн хашаа 2,000.0 мянган төгрөг, гүйцэтгэлийн төлөвлөгөөний цахим программ 3,000.0 мянган төгрөг, хүлээлгийн сандал 2,436.0 мянган төгрөгөөр худалдан авсан нь нөлөөлсөн байна.

Тайлант оны үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдлын зардал 361,997.5 мянган төгрөг байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 3,607,633.6 мянган төгрөг болж 1,007,950.3 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 596,298.7 мянган төгрөг, нийт зарлагыг 596,298.7 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлсэн байна.

Төв аймгийн Жаргалант сумын Засаг даргын Тамгын газраас дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн төсвийн төслийг 302,113.3 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, 2023 оны урсгал зардлын төсвийг 898,412.0 мянган төгрөгөөр баталж, санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 895,328.5 мянган төгрөг, шилжих үлдэгдлээс 3,083.5 мянган төгрөгөөр баталсан байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Сумын ИТХ-ын 2023 оны 8 дугаар сарын 18-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор тайлант оны батлагдсан төсөв 659,567.6 мянган төгрөгийг 238,844.4 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, 898,412.0 мянган төгрөгөөр тодотгол хийгдсэн байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага, Хүрээлэн буй орчны бодлого, удирдлага гэсэн 2 хөтөлбөрийн 9 арга хэмжээг 895,328.5 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс 3,083.5 мянган төгрөгийг урьд оны шилжих үлдэгдлээс санхүүжүүлэхээр батлагдсаны дагуу гүйцэтгэлээр санхүүжилтийг 100 хувь олгож, оны эцэст төсвийн зарцуулаагүй үлдэгдэл 48,515.2 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Тайлант хугацааны төсвийн нийт зардлын гүйцэтгэл 849,896.8 мянган төгрөг буюу 94,6 хувьтай байгаа нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллаж, бараа ажил үйлчилгээний зардлаас 48,515.2 мянган төгрөг зарцуулаагүй үлдэгдлийг татан төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/

| д/д | Хөтөлбөр | Арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | 70106-Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага | 80101- Үндсэн үйл ажиллагааны зардал | 400,623.8 | 375,543.3 | 25,080.5 | 93.74% |
| 2 | | 80103- Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ | 34,377.3 | 34,309.9 | 67.4 | 99.80% |
| 3 | | 80106- Баг, хорооны үйл ажиллагааны зардал | 193,837.5 | 178,907.4 | 14,930.1 | 92.30% |
| 4 | | 80802- Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал | 17,749.0 | 17,749.0 | 0.0 | 100.00% |
| 5 | | 80918-Бусад | 197,293.6 | 197,293.6 | 0.0 | 100.00% |
| 6 | | 81102- Орон нутгийн нөөц хөрөнгө | 5,000.0 | 4,999.4 | 0.6 | 99.99% |
| 7 | | 82801- Улсын их баяр наадам | 5,000.0 | 4,999.9 | 0.1 | 100.00% |
| 8 | 71411- Хүрээлэн буй орчны бодлого, удирдлага | 81701- Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх | 24,531.0 | 18,463.1 | 6,067.9 | 75.26% |
| 9 | | 82212- Хур хог хаягдал, орчны бохирдол | 20,000.0 | 17,631.4 | 2,368.6 | 88.16% |
| **Дүн** | | | **898,412.2** | **849,897.0** | **48,515.2** | **94.60%** |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансанд дээд шатны төсөв захирагчаас төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчдын орон нутагт ажилласны нэмэгдэл цалинд зориулан 39,174.9 мянган төгрөг, статистикийн хэлтсээс малын тооллого болон бусад судалгааны ажлын шатахуунд зориулан 3,235.4 мянган төгрөг, төсөвт байгууллагын өөрийн орлогоор болон өвс тэжээл борлуулсан орлого 5,111.0 мянган төгрөг, нийт 47,521.3 мянган төгрөгийн орлого орсон байна.

Нэмэлт санхүүжилтийн данснаас төрийн албан хаагчдын орон нутагт ажилласны нэмэгдэл цалин, нийгмийн даатгалын зардалд 35,042.6 мянган төгрөг, хагас жилийн мал тооллогын урамшуулалд 1,219.1 мянган төгрөг, актын төлбөр 1,510.2 мянган төгрөг, нийгмийн зарим үзүүлэлтийн судалгааны урамшуулал, хоолны зардал, холбооны зардалд нийт 1,194.0 мянган төгрөг, шатахууны зардалд 820.0 мянган төгрөг, өвс тэжээл бэлтгэх ажлын шатахуунд 1,615.8 мянган төгрөг, нийт 41,401.7 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Зарцуулаагүй үлдэгдэл 6,119.6 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт санхүүжилтийн дансны орлого, зардлын зарцуулалтыг зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### *3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн*

Тус төсөл хэрэгжих хугацаанд нийт хоёр хөтөлбөрийн 9 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

*Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт*

/ мянган төгрөгөөр /

| № | Хөтөлбөр | Хэрэгжих хугацаа | Хүрэх үр дүн | Хэрэгжилтийн явц | Зарцуулах төсөв | Зарцуулсан |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | 70106- Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага | 2023.01.01-2023.12.31 | Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлагыг хэрэгжүүлнэ. | Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага хөтөлбөр 95.3 % | 853,881.2 | 813,802.5 |
| 2 | 71411- Хүрээлэн буй орчны бодлого, удирдлага | 2023.01.01-2023.12.31 | Хүрээлэн буй орчны бодлого, удирдлагыг хэрэгжүүлнэ. | Хүрээлэн буй орчны бодлого, удирдлага хөтөлбөр 81.1 % | 44,531.0 | 36,094.5 |

Төв аймгийн Жаргалант сумын Засаг даргын Тамгын газар нь Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага /70106/ хөтөлбөр 95,3 хувиар, Хүрээлэн буй орчны бодлого, удирдлага /71411/ хөтөлбөр 81,1 хувиар хэрэгжсэн нь 2023 оны төсвийн жилд Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажилласантай холбоотойгоор хэмнэгдсэн 48,515.2 мянган төгрөгийг татан төвлөрүүлсэн байна.

Хүрээлэн буй орчны бодлого, удирдлага хөтөлбөрийн хур хог хаягдал, орчны бохирдол арга хэмжээ 9 хувьтай хангалтгүй хэрэгжсэн байна.

### *3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл*

Төв аймгийн Жаргалант сумын Засаг даргын Тамгын газар нь тайлант онд худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний дагуу нээлттэй 1 тендер, тендер шалгаруулалтын онцгой журмаар 15 тендерийг зарлаж, бохир соруулах болон хогны машин авах, багийн камержуулалт, гэрэлтүүлэг, гадна пасад, дээврийн засвар, бэлчээрийн болон ундны усны цахим худаг гаргах, явган хүний зам тавих, ЗДТГ-ын барилгын засварын нэмэлт ажил, сантехник, цахилгааны засвар зэрэг бүтээн байгуулалтын ажлууд хийгдсэн байна.

Ерөнхий гэрээгээр худалдан авалт хийгдээгүй байна. Энэ нь цахим дэлгүүрт бүртгэгдсэн бараа, ажил үйлчилгээний сонголт бага, өртөг зардал өндөр байгаа тул өмч хамгаалах байнгын зөвлөлийн хурлаар шийдвэрлэж, шууд худалдан авалт хийж гэрээ байгуулан ажилласан байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Жаргалант сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ц.Саранчимэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Жаргалант сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 03/45 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Төв аймгийн Жаргалант сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны батлагдсан төлөвлөгөөний нийт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Төв аймгийн Жаргалант сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны батлагдсан төлөвлөгөөний нийт зарлага 898,412.0 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 13,476.2 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75,0 хувиар буюу 10,107.4 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Тус байгууллага тайлант онд Төрийн хэмнэлтийн тухай хуулиар хориглосон зардлууд гараагүй, өглөг үүсгээгүй, төсвийн хөрөнгийг хэмнэлттэй зарцуулан хуулийг хэрэгжүүлэн ажилласантай холбоотойгоор 2 хөтөлбөрийн 9 арга хэмжээнээс хэмнэгдсэн 48,515.2 мянган төгрөгийн зардлыг татан төвлөрүүлсэн байна.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Төв аймгийн Жаргалант сумын Засаг даргын Тамгын газрын шилэн дансны хуулийн хэрэгжилтийг шалгахад Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 26, зарлагын 47 мөнгөн гүйлгээг болон өмч хөрөнгө, мөнгө зарцуулах 36 шийдвэрийг хугацаандаа байршуулж, байршуулбал зохих 159 мэдээллээс, хугацаа болоогүй 2 мэдээлэл, байршуулаагүй 12 мэдээлэл, хугацаандаа байршуулсан 145 мэдээлэл, хуулийн хэрэгжилт 75,0 хувьтай байна.

**4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Тус байгууллагад бусад хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх алдаа, зөрчилтэй асуудал гараагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

**4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**
**4.5.1 Завсрын аудитын талаар**

Төв аймгийн Жаргалант сумын Засаг даргын Тамгын газрын эхний хагас жилийн байдлаарх санхүүгийн тайланд завсрын аудит хийгдэж аудитаар нийт 22,778.8 мянган төгрөгийн зөрчилд 1,268.6 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 21,510.2 мянган төгрөгийн 4 зөвлөмж өгснийг хэрэгжүүлэн ажилласан байна.

**4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Төв аймгийн Жаргалант сумын Засаг даргын Тамгын газар нь 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар 1 төлбөрийн акт, 1 албан шаардлага, 2 зөвлөмж өгөгдсөнийг 100 хувь хэрэгжүүлэн, биелэлтийг 2023 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн 03/32 тоотоор ирүүлсэн байна.

*Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт*

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн шийдвэрлэлт | Өмнөх он | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Төлбөрийн акт | 2 | 2,086.0 | 2 | 2,086.0 | 100.0 |
| Зөвлөмж | 1 | 12,967.1 | 1 | 12,967.1 | 100.0 |
| Нийт дүн | 3 | 15,053.1 | 3 | 15,053.1 | 100.0 |

**4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Төв аймгийн Жаргалант сумын Засаг даргын Тамгын газар нь дараагийн аудитаар анхаарал татахуйц асуудлаар гүйцэтгэлийн удирдлагын мэдээллийн цахим санг нэвтрүүлэхээр “Ухаалаг засаглал” Нийгэмд үйлчлэх төрийн бус байгууллагатай гэрээ хийж, 3,000.0 мянган төгрөгийн цахим программын байнгын ажиллагаа, хөгжүүлэлт, ашиглалт, үр дүнгийн байдлыг үзнэ.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

### 5.1 Залруулга

Аудитаар нийт 1,115,721.1 мянган төгрөгийн алдаа[1], зөрчил[2] илэрснээс, аудитын явцад 48,515.2 мянган төгрөгийн алдааг залрууллаа. Үүнд:

1.Төсвийн гүйцэтгэлийн тайланд төлөвлөгөөг 48,515.2 мянган төгрөгөөр зөрүүтэй бүртгэж, төсвийн татан төвлөрүүлсэн дүнгээр тохируулга хийгээгүй, нэмэлт санхүүжилтийн тайлан нь өмнөх үеийн тоон үзүүлэлтүүдтэй зэрэгцүүлэхүйц байх зарчмыг хангаж бэлтгээгүй алдаа байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5.5-д "нэмэлт төсвийн гүйцэтгэл, түүний танилцуулга", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д "жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө" гэж заасныг болон санхүүгийн тайлангийн "иж бүрэн байх", "толилуулга" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

***<u>Шийдвэрлэсэн нь:</u>*** Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна" гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулсан.

### 5.1 Төлбөрийн акт

1.Улс төрийн 6 албан тушаалтанд орон нутгийн нэмэгдэлд 11,337.1 мянган төгрөг олгосон зөрчил байна.

Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.17-д "Захиргааны албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчид орон нутгийн нэмэгдэл олгож болно", Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д "Хариуцлагатай байх", 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4-д "хуулиар зөвшөөрөөгүй бусад", 15 дугаар зүйлийн 15.1.3-т "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" заалт, Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 489 дүгээр "Тогтоолд нэмэлт оруулж, тогтоолын хавсралтад нэмэлт өөрчлөлт оруулах тухай" тогтоол, 2018 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 382 дугаар "Журам батлах тухай" тогтоол болон санхүүгийн тайлангийн аудитын "нийцсэн бөгөөд зохистой байх", "эрх ба үүрэг" гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

***<u>Шийдвэрлэсэн нь:</u>*** Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь заалт болон Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.3.3 -д "цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон" бол төлбөрийн акт тогтооно гэж заасны дагуу шийдвэрлэв.

---

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

**5.2 Албан шаардлага**

1.Харилцагч байгууллагатай хийсэн худалдан авалтыг /дансны хуулгын дүнг/ төлбөрийн цахим баримтын дүнтэй тулгалт хийхэд ебаримтын дүн шилжүүлсэн мөнгөн дүнгээс 26,006.6 мянган төгрөгөөр зөрүүтэй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", Сангийн сайдын 347 дугаар тушаалаар батлагдсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар"-ын 6.5-д "Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм" гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн аудитын "иж бүрэн байх", "нийцсэн бөгөөд зохистой" гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

***Шийдвэрлэсэн нь:*** Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх заалт болон Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" бол албан шаардлага өгнө гэж заасны дагуу шийдвэрлэв.

**5.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

***1. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбоотой асуудал***

***1.1.Илрүүлэлт:***

Бараа үйлчилгээний бусад зардал болон бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг, ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас 19,426.0 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 5.1.5-д "хариуцлагатай байх", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх зарчим" гэсэн заалттай нийцэхгүйгээс гадна санхүүгийн тайлангийн "Эрх ба үүрэг", "Ангилал", "Үнэлгээ ба хуваарилалт" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

***1.2.Өгсөн зөвлөмж:***

Төсвийн төлөвлөлтийг боловсруулахдаа Сангийн сайдын 2021 оны 10 дугаар сарын 29-ны өдрийн 190 тоот тушаалаар батлагдсан зардлын эдийн засгийн ангилал ашиглах зааврыг мөрдлөг болгож, урсгал зардлаас хөрөнгө бэлтгэхгүй байх

***2. Бусад асуудал***

***2.1.Илрүүлэлт:***

Байгууллагын эзэмшилд байгаа 32 газраас 16 газар бүртгэлтэй байна. Газрын гэрчилгээний дугаарын дагуу, газрын хэмжээс, үнэлгээг тулгаж, данс бүртгэлд бүрэн аваагүй зөрчил байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д “хариуцлагатай байх”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.1-д “иргэдэд өмчлүүлснээс бусад газар”, 72 дугаар зүйлийн 72.4.1-д “эд хөрөнгийн тооллогыг тогтоосон хугацаанд үнэн зөв, чанартай явуулж дуусгах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх зарчим” гэсэн заалттай нийцэхгүйгээс гадна санхүүгийн тайлангийн “Эрх ба үүрэг”, “иж бүрэн байх”, “нийцсэн бөгөөд зохистой” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

***2.2. Өгсөн зөвлөмж:***

Байгууллагын эзэмшилд байх газрын кадастрын зургийг авч, санхүүгийн тайлангийн биет хөрөнгийн дансанд газрын нэршил, газрын хэмжээ, үнэлгээг үндэслэн бүртгэж авах

***3. Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой асуудал***

***3.1.1.Илрүүлэлт:***

Санхүүгийн тайлангийн үндсэн хөрөнгийн эцсийн үлдэгдлийг жилийн эцсийн тооллогын дүнтэй тулгахад зөрүүтэй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.2-т "Байгууллагын нягтлан бодогч нь үндсэн хөрөнгө, бараа материал, үнэ бүхий зүйлийн тооллогоор бэлэн байсан үлдэгдэл, гарсан зөрүүг тооллогын акт материал батлагдсанаас хойш 5 хоногийн дотор нягтлан бодох бүртгэлд тусгаж дансны үлдэгдлийг тулган шалгана” гэсэн заалттай нийцэхгүйгээс гадна санхүүгийн тайлангийн “Эрх ба үүрэг”, “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

***3.1.2.Өгсөн зөвлөмж:***

Эд хөрөнгийн тооллогын бэлтгэл ажлыг байгууллагын удирдлага, нягтлан бодогч нар бүрэн хангаж, үндсэн хөрөнгөд гарсан хөдөлгөөн өөрчлөлтийг нягтлан бодох бүртгэлд бүрэн тусгаж, техник, технологийн баримт бичгийг гүйцэд бүрэн бүрдүүлж ажиллах

***3.2.1.Илрүүлэлт:***

Үндсэн хөрөнгийн бүртгэлийг хөтлөхдөө хөрөнгийн ашиглах жилийг алдаатай оруулсан хөрөнгийн үлдэх өртгийг хасах дүнгээр алдаатай илэрхийлсэн байна.

Энэ нь "Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан “Үндсэн хөрөнгийн элэгдлийн бүртгэл” 4.35-д “Элэгдэл нь хөрөнгийн ашиглалтын хугацааны туршид элэгдүүлэх дүнг системтэйгээр хуваарилсан хуваарилалтыг хэлнэ. Тайлангийн үеийн элэгдлийн шимтгэлийг зардал гэж хүлээн зөвшөөрнө" гэсэн заалттай нийцэхгүйгээс гадна санхүүгийн тайлангийн “Үнэлгээ ба хувиарлалт”, “Тасалбар болголт” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

***3.2.2. Өгсөн зөвлөмж:***

Хөрөнгийн элэгдэл тооцох хугацааг Нягтлан бодох бодлогын баримт бичиг заасны дагуу бүртгэж тайлагнах

***3.3.1.Илрүүлэлт:***

Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 552,347.7 мянган төгрөгийн өртөгтэй 1021 ширхэг үндсэн хөрөнгө бүртгэлтэй байна.

Энэ нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 7 дугаар зүйлийн "Хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох тухай" , 7.1-д "Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ" гэсэн заалттай нийцэхгүйгээс гадна санхүүгийн тайлангийн "Үнэлгээ ба хувиарлалт", "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

***3.3.2. Өгсөн зөвлөмж:***

Аймгийн Орон нутгийн өмчийн газарт элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн хүргүүлж, шийдвэрлүүлэх

***3.4.1. Илрүүлэлт:***

Санхүүгийн тайлангийн бараа материалын эцсийн үлдэгдлийг жилийн эцсийн тооллогын дүнтэй тулгахад зөрүүтэй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.2-т "Байгууллагын нягтлан бодогч нь үндсэн хөрөнгө, бараа материал, үнэ бүхий зүйлийн тооллогоор бэлэн байсан үлдэгдэл, гарсан зөрүүг тооллогын акт материал батлагдсанаас хойш 5 хоногийн дотор нягтлан бодох бүртгэлд тусгаж дансны үлдэгдлийг тулган шалгана" гэсэн заалттай нийцэхгүйгээс гадна санхүүгийн тайлангийн "Эрх ба үүрэг", "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

***3.4.2. Өгсөн зөвлөмж:***

Эд хөрөнгийн тооллогын бэлтгэл ажлыг байгууллагын удирдлага, нягтлан бодогч нар бүрэн хангаж, бараа материалын хөдөлгөөн өөрчлөлтийг нягтлан бодох бүртгэлд бүрэн тусгаж, баримт бичгийг бүрдүүлж, тооллогын комисс ажиллуулах

***3.5.1. Илрүүлэлт:***

Бусад хангамжийн материалд 2 асар майхан 4,300.0 мянган төгрөгөөр бүртгэсэн, сэлбэг хэрэгсэл дансанд ковш тракторын сэлбэг 9,890.0 мянган төгрөг цагдаагийн машины сэлбэг 3,440.0 мянган төгрөгөөр бөөн дүнгээр бүртгэж зарлагдсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.4-д "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна", мөн хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4-д "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх" гэсэн заалттай нийцэхгүйгээс гадна санхүүгийн тайлангийн "Ангилал", "Эрх ба үүрэг", "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

***3.5.2. Өгсөн зөвлөмж:***

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт заасан хөрөнгийн ангилалын дагуу бүртгэж, бараа материалыг бөөн дүнгээр бүртгэж тайлагнахгүй байх

***4. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал***

***<u>4.1.Илрүүлэлт:</u>***

Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэлд 12 тендерийн талаар бүрэн мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д “Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална”, 4.1.1-д “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.2-т “мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх”, 4.1.3-т “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх” гэсэн заалттай нийцэхгүйгээс гадна санхүүгийн тайлангийн “Иж бүрэн байх”, “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

***<u>4.2. Өгсөн зөвлөмж:</u>***

Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэлд шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх мэдээллийг бүрэн оруулах

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасан хугацаанд ирүүлж, акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг 2024 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА,ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

### 6.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Төсвийн гүйцэтгэлийн тайланд төлөвлөгөөг зөрүүтэй оруулж, төсвийн татан төвлөрүүлсэн дүнгээр тохируулга хийгээгүй байна. Төсвийн гүйцэтгэл, Нэмэлт санхүүжилтийн тайлан бүрэн гараагүй байна. | 1 | 48515.2 | 1 | 48515.2 | | | 1 | 48515.2 | | | | |
| Дүн | 1 | 48515.2 | 1 | 48515.2 | 0 | 0 | 1 | 48515.2 | 0 | 0 | 0 | 0 |

### 6.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Улс төрийн 6 албан тушаалтанд орон нутгийн нэмэгдэлд олгосон зөрчил байна. | 1 | 11,337.1 | 1 | 11,337.1 | | | | | | | | |
| Харилцагч байгууллагатай хийсэн худалдан авалтыг /дансны хуулгын дүнг/ төлбөрийн цахим баримтын дүнтэй тулгалт хийхэд ебаримтын дүн шилжүүлсэн мөнгөн дүнгээс зөрүүтэй байна. | 1 | 26,006.6 | | | 1 | 26,006.6 | | | | | | |
| Бараа үйлчилгээний бусад зардал болон бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг, ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас хөрөнгө бэлтгэсэн байна. . | 1 | 19,426.0 | | | | | 1 | 19,426.0 | | | | |
| Байгууллагын эзэмшилд байгаа 32 газраас 16 газар бүртгэж, гэрчилгээний дугаар, газрын хэмжээс, үнэлгээг тулгаж, данс бүртгэлд бүрэн аваагүй байна. | 1 | 967,091.2 | | | | | 1 | 967,091.2 | | | | |
| Санхүүгийн тайлангийн үндсэн хөрөнгийн эцсийн үлдэгдлийг жилийн эцсийн тооллогын дүнтэй тулгахад зөрүүтэй байна. | 1 | - | | | | | 1 | 0.0 | | | | |
| Үндсэн хөрөнгийн ашиглах жилийг алдаатай оруулсан, хөрөнгийн үлдэх өртгийг хасах дүнгээр алдаатай илэрхийлсэн байна. | 1 | - | | | | | 1 | 0.0 | | | | |
| Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн үндсэн хөрөнгө бүртгэлтэй байна. | 1 | - | | | | | 1 | 0.0 | | | | |
| Санхүүгийн тайлангийн бараа материалын эцсийн үлдэгдлийг жилийн эцсийн тооллогын дүнтэй тулгахад зөрүүтэй байна. | 1 | 25,715.0 | | | | | 1 | 25,715.0 | | | | |
| Бусад хангамжийн материалд 2 асар майхан бүртгэсэн, сэлбэг хэрэгсэл дансанд ковш тракторын болон цагдаагийн машины сэлбэгийг бөөн дүнгээр бүртгэж зарлагдсан байна. | 1 | 17,630.0 | | | | | 1 | 17,630.0 | | | | |
| Дүн | 7 | 1,067,205.9 | 1 | 11,337.1 | 1 | 26,006.6 | 6 | 1,029,862.2 | | | | |

## 6.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

мянган төгрөгөөр

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэлд 12 тендерийн талаар бүрэн мэдээлэлээгүй байна. | 1 | - | | | | | 1 | - |
| Дүн | 1 | | | | | | 1 | |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| Дүн | | | | | | | | |
| Нийт дүн | 1 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 1 | 0 |